

VI ангийн УЗ-ын хичээлийн дасгал ажил /I улирал/

1

Сурагчийн овог нэр:

Эхэлсэнонсарөдөрцаг
Дууссанонсарөдөрцаг

Бүлэг сэдэв: Монгол домог, үлгэр

Хичээлийн сэдэв: Домгийг уншаад хам сэдвийн хүрээнд тусган хүлээн авах

Зорилго: Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна.

Агуулгын товч тайлбар: Хам сэдэв гэдэг бол зохиолын дүрийг тодорхойлж буй тухайн цаг үеийн нийгэм-соёлын нөлөө, үйл явдал, үзэл бодол зэрэг зохиолын хамгийн их мэдээлэлтэй хэсэг юм. Үүнд: нийгмийн, түүхийн, соёлын хам сэдэв зэрэг багтана.

Аливаа үндэстний ёс заншил, соёл, сэтгэлгээ, шашин, аж амьдралын хэв маяг зэрэг нь зохиол бүтээлд тусгагдсаныг соёлын хам сэдэв гэнэ.



Уран зохиолын сурах бичгийн 12 дугаар талд буй “Хуур хөгжим үүссэн нь” домгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1. Зохиолын агуулгыг ойлгосноо сэргээн саная.

Алхам I. Бурхан багш юуны учир хуур хийхээр болсон бэ?

.....

Алхам II. Бурхан багш зорилгодоо хүрэхийн тулд хэн хэнтэй уулзаж, ямар зөвлөгөө авсныг зохиолоос эш татан нөхөж бичээрэй.

.....
.....
.....
.....



.....
.....
.....
.....

Алхам III. Домогт морин хуурыг ямар ямар эд ангиас бүтсэн гэж дүрсэлсэн бэ?

.....

.....

.....



.....

.....

.....


Дасгал 2 . Домогт монголчуудын ямар соёл сэтгэлгээ туссан байна вэ?



Алхам I. “Хэлсэн ёсоор нь мод дөрвөлжлөөд, могойн арьсаар гадарлаад, морины сүүлээр хялгаслаад, махир модоор онь хийгээд дуу гаргах гэсэн чинь хяхарч чахраад л санаанд нь хүрсэнгүй.” дараах өгүүлбэрт зурхайчийн хэлсэн ёсоор хуураа хийсэн боловч юу дутсан бэ? Үсгүүдийн байрыг сольж зөв хариуг бүтээгээрэй.

□	□	□	□	□	□	□	□
А	Д	Р	В	Й	А	Й	Х

Алхам II. Бидний соёлын өв болох хуур хөгжмийн аялгуу эгшиглэнтэй сайхан сонсогддогийн гол шалтгаан нь юу бол? Өөрийн таамаглалаа жишээгээр батлан бичээрэй.




.....

.....

.....

Дасгал 3. Домгийн сэдэв, гол санааг газрын зургаас зөв олж ялган будаарай.



Хуур хөгжим үүссэн тухай


Хуур хөгжим хүний сэтгэлийг тайвшруулдаг.

Бурхан багшийн тухай


Бурхан багш хуур хөгжмийг бүтээжээ.

Чөтгөр бурханд тусалсан тухай

Чөтгөр хуур хөгжмийг бүтээжээ.



Дасгал 4. Домогт монголчууд бидний ямар өв соёлын талаар өгүүлсэн бэ? Үүгээр ямар хам сэдэв илэрч байна вэ?



.....
.....
.....
.....

2	Сурагчийн овог нэр:	Эхэлсэнонсарөдөрцаг Дууссанонсарөдөрцаг
---	---------------------	--

Бүлэг сэдэв: Монгол домог, үлгэр

Хичээлийн сэдэв: Домгийг уншаад сэдэв, гол санааг тайлбарлах

Зорилго: Сурагчид зохиолын сэдэв, гол санааны уялдаа холбоог дүгнэж тайлбарладаг болно.

Агуулгын товч тайлбар:

Зохиогчийн сэдэн дэвшүүлсэн асуудлыг зохиолын **сэдэв** гэнэ.

Сэдвээс гаргасан дүгнэлтийг зохиолын **гол санаа** гэнэ.

Зохиолд юуны тухай өгүүлсэн бэ? **Сэдэв**

Зохиолоос юу ойлгож ухаарсан бэ? **Гол санаа**

Уран зохиолын сурах бичгийн 9 дугаар талд буй “Тэмээ үнсэнд хөрвөөх болсны учир” домгийг анхааралтай уншиж <https://www.youtube.com/watch?v=m0VdII4kdFs> дараах холбоосоор домгоос сэдэвлэн бүтээсэн хүүхэлдэйн киног үзээрэй.

Дасгал 1. Домгоо сэргээн саная.

Алхам I. Бурхан юуны учир “Өөрсдөө шийд” гэж хэлсэн бэ?

.....

Алхам II. Арван хоёр жилд багтах мэлзээ шударга байсан уу? Яагаад?

.....
.....

Алхам III. Тэмээ арван хоёр жилд багтаагүй боловч арван хоёр жилд багтсан бүх амьтны шинжийг цөмийг биедээ агуулсан байдаг тухай домогт өгүүлжээ. Тэгвэл тэмээний шинжийг зөв тохируулаарай.

- | | |
|------------|-------------|
| 1. Хулгана | a. ноостой |
| 2. Үхэр | b. нүдтэй |
| 3. Бар | c. хамартай |
| 4. Туулай | d. тавагтай |

- | | |
|-----------|---------------|
| 5. Луу | е. гятай |
| 6. Могой | ф. гэдэстэй |
| 7. Морин | г. өрөвлөгтэй |
| 8. Хонин | h. чихтэй |
| 9. Бичин | i. сүүлтэй |
| 10. Тахиа | j. дэлтэй |
| 11. Нохой | k. биетэй |
| 12. Гахай | l. бөхтэй |



Дасгал 2. Домогт юуны тухай өгүүлж байна вэ? Сэдвийг тодорхойлоорой.

.....

Дасгал 3. Энэхүү домгоор дамжуулан өвөг дээдэс маань бидэнд юуг ойлгуулахыг зорьсон бол? Зохиолын гол санааг эргэцүүлэн бичээрэй.

.....

.....

.....

3

Сурагчийн овог нэр:

Эхэлсэнонсарөдөрцаг
 Дууссанонсарөдөрцаг

Бүлэг сэдэв: Монгол домог, үлгэр

Хичээлийн сэдэв: Домгийн орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таних

Зорилго: Сурагч зохиолын үйл явдал өрнөсөн орон ба цагийн дүрслэлийг ялган таньж, гол санаатай холбож сурна.

Агуулгын товч тайлбар:

Зохиолын үйл явдал хэзээ, хаана өрнөж буйг илтгэх орон ба цагийн дүрслэл.

Цагийг судлахдаа:

- Зохиолд үзүүлж буй цаг нь бодит тодорхой түүхэн цаг байна уу? Эсвэл ерөнхий эрт цаг үе байна уу?
- Зохиолд дүрслэгдсэн цаг үе нь одоогийн амьдарч буй цаг үеийн хооронд хэр хол хугацаа байгааг харьцуулна.

Орныг судлахдаа:

- Зохиолд үзүүлсэн орон бодит тодорхой газар орон байна уу? Эсвэл ерөнхий нэг орон байна уу?
- Ямар түлхүүр үгс болон ямар дүрслэлийг ашигласан байна вэ?



Уран зохиолын сурах бичгийн 6 дугаар талд буй “Дэлхий анх тогтсон нь” домгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1. Зохиолын эхлэл хэсгийн үйл явдал хэзээ, хаана өрнөсөн бэ?


Эрт урьд цагт гэнэ. Шагжамуни анхны хүсэл сэтгэлчлэн бүтсэнд туйлын их баярлаж байжээ. Хурмаст тэнгэр: “Доод газар дээр юу болж байна?” гэж асуусанд “Эзэн минь, тэнд газар гэх юмгүй, уснаас өөр юу ч үгүй” гэжээ.

.....
.....

Дасгал 2. Зохиолын орон цаашид хэрхэн өөрчлөгдсөн бэ? Дэлхий анх ямар байснаас яаж өөрчлөгдсөн тухай зохиолоос эш татан бичээрэй.



1.....
.....



2.....
.....
.....



3.....
.....
.....




4.....
.....
.....

Дасгал 3. “... шар шороог аваад дөрвөн далайн хамгийн ахмад зүүн далайн тэг дунд нь шидчихээд, харж хүлээж бай. Тэгтэл аяндаа сүүнд өрөм тогтож байгаа юм шиг газар дэлхий биежээд ирнэ” гэсэн өгүүлбэр орныг хэрхэн дүрсэлснийг тайлбарлан бичээрэй.

.....
.....
.....

Дасгал 4. Домгийн төгсгөл хэсгийг уншаад зүг чиг, байрлал заасан үгсийг нөхөж бичээрэй.



Дасгал 5. Зохиолын орон цагийн дүрслэл нь гол санаатай яаж холбогдож байна вэ?

Алхам I. Зохиолын гол санааг илэрхийлсэн хэсгийг сонгоорой.

- A. Хурмаст тэнгэр, Шагжамуни газар дэлхийг бий болжээ.
- B. Хөхтэй мэргэн мэлхийг харваснаас зүг чиг бий болжээ.
- C. Газар дэлхий шар шорооноос бий болжээ.

Алхам II. Зохиолын орон ба цагийн дүрслэл нь гол санаатай яаж холбогдож байна вэ?

.....

4	Сурагчийн овог нэр:	Эхэлсэнонсарөдөрцаг Дууссанонсарөдөрцаг
---	---------------------	--

Бүлэг сэдэв: Монгол ардын домог, үлгэр

Хичээлийн сэдэв: Үлгэрийн өгүүлэгдэхүүнийг үйл явдлын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллаар ялган таних

Зорилго: Сурагч зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллыг ялган таньдаг болно.

Агуулгын товч тайлбар: Зохиолын үйл явдлын бүтэц дарааллыг зохиолын өгүүлэгдэхүүн гэнэ.

1. Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдлыг **эхлэл** гэнэ.
2. Зохиолын үйл явдал үргэлжлэх зөрчил мөргөлдөөн үүсэх шалтгааныг зохиолын **зангилаа** гэнэ.
3. Зохиолын зангилаанаас учир шалтгааныг олохын тулд цааш үргэлжилж байгаа хэсгийг **өрнөл** гэнэ.
4. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж туйлдаа хүрсэн хэсгийг зохиолын **туйл** гэнэ.
5. Зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар яаж шийдэгдэж байгааг **тайлал** гэнэ.
6. Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг **төгсгөл** гэнэ.



Уран зохиолын сурах бичгийн 20, 21 дүгээр талд буй “Арсландай мэргэн хаан” үлгэрийг анхааралтай уншаарай.

<https://econtent.edu.mn/lessons/EBS/6rangi/uran/3837> дараах холбоосоор нэвтрэн теле хичээлээ нөхөж үзээрэй.

Дасгал 1. Зохиолын эхлэл хэсгийг тодорхойлъя.

Алхам I. Эхлэл хэсэгт ямар ямар дүрүүд дүрслэгдсэн бэ?

A. Арсландай мэргэн хаан

B. Арсландай мэргэн хаан, гурван саарал

C. Гурван чоно

Зохиол эхлэхдээ юуны тухай танилцуулж байна вэ? Ямар ямар дүр гарах бол? Байгалийн ямар байдал дүрслэгдэв?

Алхам II. Үлгэрийн эхлэл хэсэгт юуны тухай гарч байна вэ?



A. Арсландай мэргэн хааны тухай

B. Адууны тухай

C. Арсландай мэргэн хааны адуун сүрэг асар арвин байдаг тухай

Дасгал 2. Зохиолын зангилааг тодорхойлъя.

Алхам I. Арсландай мэргэн хаан яагаад гурван саарлыг авлахаар болсон бэ?

A. Арсландай мэргэн хаан ан ав хийх дуртай.

B. Гурван саарал хоттой хониноос нь хороосон.

C. Гурван саарал Арсландай мэргэн хааны адуун сүргээс хороосон.



Алхам II. Гурван саарал Арсландай мэргэн хааны адуун сүргээс хороогоогүй бол үйл явдал цаашид өрнөх байсан уу? Яагаад?

.....

.....

.....

Дасгал 3. Зохиолын өрнөл хэсгийг ялгая. Арсландай мэргэн хааны аргыг мэдсэн гурван саарлын үйлдлийг зөв харгалзуулж цэгийн оронд тохирохыг нөхөж бичээрэй.

Арсландай мэргэн
хааны арга

Гурван саарал чононы арга



1.....
.....
.....

A.
.....
.....



2. Халиу гүйцдэг халтар
халзнаараа хөөгөөд
авлачихна даа.

B.
.....
.....



3.....
.....
.....

C. Жигүүртэн шувууг ч урдаа оруулдаггүй
морь доо. Энэ шөнө л түүнийг идэх арга
хийе гэв.

Дасгал 4. Зохиолын дүрүүдийн зөрчил хурцдаж, эцэстээ хүрсэн /туйл/ хэсгийг тодруулъя.

Алхам I. Гурван саарлын зөрчилдсөн баримтыг өгөгдсөн дугуй дүрсэнд 1-4 хүртэлх тоог тавьж, зөв дараалалд оруулаарай.



Өнөө хоёр үсэрч очоод, нэг тарган гүү унагаад авчээ. Цадталаа идэж гэнэ.



Бөөн саарал, Хурдан саарал хоёр нь хэлжээ, – Өдий олныг харж байж адасга шиг туранхай энэ мүү морийг идвэл арай азанд мүү болох биз.



Шөнө дундаас хойш нэг алгын чинээ адасга шиг туранхай хүрэн морь тааралджээ.



Мэргэн саарал чоно: – Үүнийг л идье! Гурвуул зулгааж идвэл бидний хэрэг бүтнэ гэжээ.

Алхам II. Үйл явдлын зөрчил туйлдаа хүрсэн хэсэг хаана байна вэ? Үлгэрээс ялган бичээрэй.

.....
.....
.....
.....



Дасгал 5. Гурван саарлын зөрчлөөс болж ямар үр дагавар үүссэн бэ?



Дасгал 6. Зохиолын өгүүлэгдэхүүн тус бүрийн гол санааг нэг өгүүлбэрээр хурааж бичээрэй.

Өгүүлэгдэхүүн		Гол санааг хадгалсан товч өгүүлбэр
1	Эхлэл	Ай түмэн живаа адуутай Арсландай мэргэн хаан байжээ.
2	Зангилаа
3	Өрнөл	Мэргэн саарал: – Алтай Хангайн ар орой дээр нэг уулзья – Ардаг хүрэн морины ар зоон дээр нэг уулзья – Арсландай мэргэн хааны ар мөрөн дээр нэг уулзья гэж хэлээд давхиад явчихжээ.
4	Туйл
5	Тайлал
6	Төгсгөл

5	Сурагчийн овог нэр:	Эхэлсэнонсарөдөрцаг Дууссанонсарөдөрцаг
---	---------------------	--

Бүлэг сэдэв: Монгол ардын домог, үлгэр

Хичээлийн сэдэв: Үлгэрийг уншаад дүрийн зан төрхийг тайлбарлаж, зорилгыг тодорхойлох

Зорилго: Сурагч зохиолын дүрийн зан чанараас зорилгыг нь тодорхойлдог.

Агуулгын товч тайлбар: Дүр бол зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилааг тээж явдаг нэг төлөөлөл байдаг. Дүрүүд нь хүн амьтан, робот гэхчлэн зохиолчийн сонгосон юу ч байж болно.


Дүрийн зан төрхийг тайлбарлахдаа дүрийн хэлсэн үг, бодол, харилцан яриа, хийсэн үйлийг ажиглана.

Дүр зорилгодоо ямар арга замаар хүрснийг эргэцүүлж, зөв буруу алин болохыг



Уран зохиолын сурах бичгийн 15, 16 дугаар талд буй “Аргат улаан үнэг” үлгэрийг анхааралтай уншаарай. <https://econtent.edu.mn/lessons/EBS/6rangi/uran/3626> дараах холбоосоор нэвтрэн теле хичээлээ нөхөж үзээрэй.

Дасгал 1. Үлгэрт гар буй дүрүүдийг цэгийн оронд бичээрэй.



Дасгал 2. Дүрийн зан төрхийг дүгнэн тайлбарлая.

Алхам I. Хүснэгтэд дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлийг нөхөж бичээрэй.

Алхам II. Дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс нь зан төрхийг дүгнэн бичээрэй.

Дүр	Хэлсэн үг	Хийсэн үйлдэл	Дүрийн зан төрхийг дүгнээрэй.
Хүү	-Нэг үнэг аль хэдийн тэр хамар дээгүүр даваад явчихсан. -Би оготно, зурамхан урхи тороор барьж, амь зуудаг хүн. -Тэр ямар зүг байх вэ? Харин миний урхинд орж баригдах тийм чоно хаанаас байх вэ дээ.
Чоно	Гэнэн итгэмтгий

Бүлэг сэдэв: Монгол ардын аман яруу найраг

Хичээлийн сэдэв: Монгол ардын аман яруу найргийг уншаад хам сэдвийн хүрээнд тусган хүлээн авах

Зорилго: Сурагч аман яруу найргаас ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна.

Агуулгын товч тайлбар: Аливаа үндэстний ёс заншил, соёл, сэтгэлгээ, шашин, аж амьдралын хэв маяг зэрэг нь зохиол бүтээлд тусгагдсаныг соёлын хам сэдэв гэнэ.

Аливаа юмс үзэгдлийн онцлог шинжийг ёгт битүүгээр хэлж нэрийг нь таалгах уран асуултыг оньсого гэнэ. Оньсого нь:

1. Хүний ой ухаан, авьяасыг шалгадаг.
2. Бодож сэтгэх чадварыг хөгжүүлдэг.
3. Танин мэдэхүйн зорилготой.

Дасгал 1. Дараах оньсогыг уншаад юуг юутай адилтгасныг зөв тохируулаарай.

- | | |
|------------------------------------|------------------|
| 1. Алтай Хангайн ард гэнэ | а. Үүрийн цолмон |
| 2. Арван түмэн адуу гэнэ | б. од |
| 3. Цойлсон долоо гэнэ | в. тэнгэр |
| 4. Цугласан зургаа гэнэ | г. Нар, сар |
| 5. Цуварсан гурав гэнэ | д. Долоон бурхан |
| 6. Хар, цагааныг ялгасан хоёр гэнэ | е. мичид |
| 7. Хаягдаж хоцорсон нэг гэнэ | ё. Марал |

Дасгал 2. Дараах оньсогот юуг юутай адилтгасан байна вэ? Тайлбарлан бичээрэй.

Шар торгыг шаглаж болдоггүй

Хар торгыг хажиж болдоггүй

(Тэнгэр, газар)

.....

.....

Дасгал 3. Тэнгэрийн шинжийг өөр ямар нэгэн зүйлтэй адилтган оньсого зохиогоорой.

.....

.....

Дасгал 4. Дараах оньсогот ямар дүрслэх ур маяг байна вэ?

Их шаргыг унаад

Бага шаргыг хөтлөөд

Талын адууг

Тас хураана. /Аргал түүх/



- А. Багасгал, адилтгал
Б. Адилтгал
В. Амьдчилал
Г. Хэтрүүлэл

Дасгал 5. Оньсого таалцах нь ямар ямар ач холбогдолтой вэ?

-
-

7	Сурагчийн овог нэр:	Эхэлсэнонсарөдөрцаг Дууссанонсарөдөрцаг
---	---------------------	--

Бүлэг сэдэв: Монгол ардын яруу найраг

Хичээлийн сэдэв: Яруу найргийн үг сонголт, уран дүрслэл (адилтгал, амьдчилал, хэтрүүлэл)-ийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах

Зорилго: Сурагч уншсан зохиолын бүтэц- агуулга, хэл-уран дүрслэл, сэдэв-гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг тодорхойлж чаддаг болсон байна.


Агуулгын товч тайлбар: Өгүүлж байгаа зүйлийг уран дүрслэлтэй болгохын тулд **үгийн утгыг шилжүүлж** хэрэглэснийг уран дүрслэл гэнэ.

Юм үзэгдлийн аль нэг шинжийг товойлгох зорилгоор түүнтэй төстэй өөр юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн нэрлэх дүрслэх ур маягийг **адилтгал** гэнэ. Жишээ нь: Газрын нүдэн булаг, хөрөөний ир шиг намхан уулс гэх мэт.

Амьгүй юмыг адгуус амьтны хийдэг үйлдэл хийлгэж, амьтай мэт дүрслэх ур маягийг **амьдчилал** гэнэ. Жишээ нь: Ховдог цэцэгс шүүдрээ бухна, холын уулс сүүдрээ шилгээнэ. /бухах-гэм зэмлэлийг бусдад түлхэж зайлах, мэлзэх, няцах/

Адгуус амьтан, амьгүй юмыг хүний хийдэг үйлдэл хийлгэж, амьтай мэт дүрслэх ур маягийг **хүншүүлэл** гэнэ. Жишээ нь: Улаанбаатар хот минь элгээ хөштөл хөхрөх байх даа.

Юм, үзэгдэл, үйл явдлын аль нэг шинж байдлыг ерийнхөөс нь **ихэсгэн хэтрүүлэх, багасган хэтрүүлэх** дүрслэх ур маяг. Жишээ нь: Төмөр дөрөөний сэнжийг сэтэртэл

 Уран зохиолын сурах бичгийн 46 дугаар талд буй “Монголын тал нутаг” шүлгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1. Зохиогчийн үг сонголтын учрыг тайлбарлая.

Алхам I. Дараах зургийг сайтар ажиглаад “Монголын тал нутаг” шүлэгтэй харьцуулан ямар мэдрэмж сэтгэгдэл төрснөө илэрхийлэн бичээрэй.



.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Алхам II. Шүлэгт буй “дүүжүү, цавгүй” гэсэн үгсийн утгыг хам бүтцээс нь таамаглан тайлбарлаарай.

Дүүжүү -

Цавгүй -

Алхам III. “Алман цагаан саран

Тормос тормос мишээхэд

Алтан мөнгөн одод

Тодрон тодрон жирвэлзэнэ”

Энэ хэсэг ямар үгсийг давтсан байна вэ? Шүлэгт яагаад үг давтан хэрэглэснийг таамаглан тайлбарлаарай.

Дасгал 2. Шүлгийн дахилт асуултаар төгсөж байгаа нь ямар үүрэгтэй байна вэ? Хэрэв асуултгүй байсан бол шүлэгт ямар өөрлөлт гарах вэ?

“Ямар уудам юм бэ?
Монголын тал нутаг
Яасан уужуу юм бэ?
Монгол хүний сэтгэл”

Дасгал 3. Шүлэгт буй уран дүрслэлийг тайлбарлая.

Алхам I. Зохиолч юуг юутай адилтгасан байна вэ? Үүгээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэн бэ? Таамаглан бичээрэй.

Бадаг	Юуг юутай адилтгасан бэ?	Уншигчдад юуг ойлгуулахыг хүссэн бэ?	Дүрслэх ур маяг
I бадаг

Алхам II. Шүлэгт ертөнцөд байдаг амьгүй ямар зүйлсийг амьтай болгон, хүний зан араншинг шингээсэн бэ? Үүгээрээ зохиолч уншигчдад юуг хэлэхийг хүссэн бэ?

.....
.....

8	Сурагчийн овог нэр:	Эхэлсэнонсарөдөрцаг Дууссанонсарөдөрцаг
---	---------------------	--


Бүлэг сэдэв: Монгол ардын яруу найраг

Хичээлийн сэдэв: Шүлгийн сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичих

Зорилго: Сурагч уншсан зохиолыг ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлж сурна.

Агуулгын товч тайлбар: Мэдрэмж - Харах, сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх 5 мэдрэхүйгээр дамжин илрэх онцгой чадвар бөгөөд зарим зүйлд хариу үйлдэл үзүүлэх, түүнийг таних, үнэлэх, ойлгох чадвар юм. Өөрөөр хэлбэл гадаад орчныг мэдрэлдээ хүлээн авах чанар юм.

Сэтгэгдэл – Бодит байдал болон мэдрэмжээс төрсөн бодол бол сэтгэгдэл юм.


 Уран зохиолын сурах бичгийн 45 дугаар талд буй “Нүүдлийн цай” шүлгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1. Дараах үгсийн утгыг зөв харгалзуулаарай.

- | | |
|-----------|--|
| 1. Зөөхий | А. Шингэн зүл агуулах, цоргогүй хараатай сав |
| 2. Домбо | В. Нутаг сонгож, нэг газраас нөгөөд шилжин явах |
| 3. Нүүдэл | С. Буцалгаад самралгүй хөргөсөн сүүний дээгүүр тогтсон тослог зүйл |

Дасгал 2. Дүрийн үйлдлээс дүгнэлт гаргая.

Алхам I. Ээжийн хийж байгаа үйлдлүүдээс ёс заншилтай холбоотой хэсгийг шүлгээс түүн бичээрэй.



Алхам II. Ээжийн хийж буй үйлдлээс ээжийн дүрийг тодорхойлон бичнэ үү.

.....
.....
.....

Дасгал 3. Мэдрэмжээ илэрхийлье.

Алхам I. “Өрөм зөөхийнд хөөрцөглөж

Хийц амтыг нь болгооно.” шүлгийн дараах хэсгээс ээжийн сэтгэлээ шингээж чанасан нүүдлийн цайны амтыг мэдэрье. Төсөөлөн бодоод бичээрэй.



Амт нь?

Үнэр нь?

Өнгө нь?

Алхам II. Шүлгээс юу мэдэрч байгаагаа илэрхийлэн бичнэ үү?

.....
.....
.....

Дасгал 4. Хүүхдүүд бидний уламжлан авч үлдэх ямар ёс заншил байна вэ? Шүлгийн талаар эргэцүүлэн бодоод төрсөн сэтгэгдлээ бичээрэй.

.....
.....
.....
.....

9


Сурагчийн овог нэр:


Эхэлсэнонсарөдөрцаг
Дууссанонсарөдөрцаг

Бүлэг сэдэв: Монгол ардын яруу найраг

Хичээлийн сэдэв: Шүлгийн хэлбэрийг дуурайн зохиох

Зорилго: Сурагч шүлэгт өгүүлсэн зүйлийг өөрчлөн хэлбэрийг нь дуурайн зохиож сурна.

 **Агуулгын товч тайлбар:** Шүлгийн бадгийн бүтцийг бий болгоход оролцож буй авианы давталтыг холбоц гэнэ. Холбоц гэдэг нь шүлгийн мөрүүдийг холбох уран сайхны өвөрмөц арга. Толгой холболт - Эхний үг, авиаг давтах
Сүүл холболт - сүүлийн үг, авиаг давтах
Шүлгийн нэг мөрийг шад гэнэ.

 Уран зохиолын сурах бичгийн 37 дугаар талд буй “Гурван сүлжээ сургаал” шүлгийг анхааралтай уншаарай. <https://www.youtube.com/watch?v=RMFxTfGQgnM> дараах холбоосоор шүлгээ бүрэн эхээр нь сонсоорой.

Дасгал 1. Шүлгийг “Гурамсан сүлжээ” гэж нэрлэсний учрыг жишээ татан тайлбарлаарай.

.....

.....


**Дасгал 2. “Эгшин бүрийд цэнгүүштэй нь
Бие, хэл, сэтгэл гурав
Эгнэгт тордож явууштай нь
Билиг, ухаан, чадал гурав” шүлэгт “–ууштай”-г сонгож авсны учрыг таамаглан тайлбарлан бичээрэй.**



Дасгал 3. Шүлгээс ухаарч ойлгосон зүйлээ бичнэ үү?



Өсөхийн цагт санууштай нь
Бишрэл, хичээл, сэтгэл гурав.
Өөдлөхийн тулд нягтлууштай нь
Сургаал, үнэн, үлгэр гурав.
Ачлахын дээдээр ачлууштай нь
Ээж, аав, эх орон гурав.
Асрахын дээдээр асрууштай нь
Өтгөс, нялхас, хань гурав.



Дасгал 4. “Гурван сүлжээ сургаал”-ын шүлгийн хэсгийг дуурайн зохиогоорой.


Санамж: 8 шад шүлэг бичнэ гэж төлөвлөөрэй.
Шад бүрд байх түлхүүр үгээ олоорой.
Шүлгийн шад доторх үгээ тооцоолоорой.
Толгой ба сүүл холбож бичээрэй.

Жишээбэл:

Өсөхийн цагт санууштай нь
Бишрэл, хичээл, сэтгэл гурав.
Өөдлөхийн тулд нягтлууштай нь
Сургаал, үнэн, үлгэр гурав.
Ачлахын дээдээр ачлууштай нь
Ээж, аав, эх орон гурав.
Асрахын дээдээр асрууштай нь
Өтгөс, нялхас, хань гурав.



Сурахын цагт дээдлүүштэй нь
Багш, ном, зүтгэл гурав
Сэтгэн бодохын үндэс нь
Унших, бичих, ойлгох гурав
Хүний насны хэмжүүр нь
Хүүхэд, залуу, өтөл гурав
Хөгжин дэвшихийн үндэс нь
Ажил, хөдөлмөр, зорилго гурав.




Дараах хэсгийг дуурайн зохионо уу.

Ялахын түрүүнд ялууштай нь
Нойр, залхуу, атаа гурав
Яруу төгс сурууштай нь
Яриа, дуу, хөгжим гурав
Эгшин бүрийд цэгнүүштэй нь
Бие, хэл, сэтгэл гурав
Эгнэгт тордож явууштай нь
Билиг, ухаан, чадал гурав.



.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....



VI ангийн УЗ-ын хичээлийн дасгал ажил /II, III улирал/

1

Сурагчийн овог нэр:

Эхэлсэнонсар
.....өдөрцаг

Бүлэг сэдэв: Монголын уран зохиол өгүүллэг, тууж

Хичээлийн сэдэв: Зохиолын дүрийн үг, үйлдлээр зорилгыг тодорхойлох



Бид энэ хичээлээр юу мэддэг, чаддаг болох вэ?

Зохиолын дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс зорилгыг нь тодорхойлж сурна.



Агуулгын товч тайлбар: Дүр бол зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилааг тээж явдаг нэг төлөөлөл байдаг. Дүрүүд нь хүн амьтан, робот гэхчлэн зохиолчийн сонгосон юу ч байж болно.

Дүрийн зан төрхийг тайлбарлахдаа дүрийн хэлсэн үг, бодол, харилцан яриа, хийсэн үйлийг ажиглана.

Дүр зорилгодоо ямар арга замаар хүрснийг эргэцүүлж, зөв буруу алин болохыг дүгнэх




Уран зохиолын сурах бичгийн 52, 53 дугаар талд буй П.Хорлоо “Алт, Мөнгө хоёр” өгүүллэгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1

Дүрийн зан төрхийг тайлбарлая.

Алхам I. Зохиолд ямар ямар дүр гарч байна вэ?



Алхам II. Зохиолоос Алтын хэлсэн үг, хийсэн үйлдэл, бодсон бодол, харилцан яриаг ялган бичээрэй.

<p>Хэлсэн үг</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>Хийсэн үйлдэл</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>
---	---



Бодсон бодол

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Алхам III. Алтын бодсон бодол, хэлсэн үг, хийсэн үйлдлээс түүний зан чанарыг таамаглан тодорхойлоорой.

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	

Алхам IV. Зохиолын эхлэлээс төгсгөл хүртэл Алтын зан төрх хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхойлж бичээрэй.

<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	<p>.....</p> <p>.....</p> <p>.....</p>	
--	--	--	--

Дасгал 2

Дүрийн зорилгыг тодорхойлъя.

Алхам I. Зохиолоос Мөнгийн хэлсэн үг, хийсэн үйлдэл, бодсон бодол, харилцан яриаг ялган бичээрэй.

Хэлсэн үг

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Хийсэн үйлдэл

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Бодсон бодол

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Алхам II. Алт, Мөнгө хоёрын анхны зорилго юу байсан бэ?

.....

.....

.....

Алхам III. Мөнгө хүүгийн зорилгыг тодорхойлоорой.

Ямар зорилготой байв?

.....

.....

.....

.....

.....

Зорилгодоо хүрэхэд ямар саад бэрхшээл тулгарав?

.....

.....

.....

Саад бэрхшээлийг хэрхэн давав?

.....

.....

.....

.....

Зорилгодоо хүрч чадсан уу?

.....

.....

.....

Дасгал 3

Хэрвээ би “Мөнгийн оронд байсан бол Алтад хэлэх үг”-ийг төсөөлөн бодож бичээрэй.



Дууссанонсар
.....өдөрцаг

Өөрийн үнэлгээ: Хүүхдүүд ээ, дараах хүснэгтэд ажилласан дасгалын дугаарыг бичээд, багшаасаа асуух, тодруулах, тухайн даалгаврын хүрээнд онцлон тэмдэглэх зүйлээ бичээрэй.



Маш сайн ойлгож хийсэн дасгал



Эргэлзэж хийсэн дасгал



Тусламж хэрэгтэй дасгал



Бүлэг сэдэв: Монголын уран зохиол өгүүллэг, тууж

Хичээлийн сэдэв: Зохиолын орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таних



Бид энэ хичээлээр юу мэддэг, чаддаг болох вэ?

Зохиолын орон ба цагийн дүрслэлийг ялган, хэрхэн дүрсэлснийг тайлбарлаж сурна.



Агуулгын товч тайлбар: Зохиолын үйл явдал хэзээ, хаана өрнөж буйг илтгэх орон ба цагийн дүрслэлийг зохиолын орчин гэнэ.

Цагийг судлахдаа:

- Зохиолд үзүүлж буй цаг нь бодит тодорхой түүхэн цаг байна уу? Эсвэл ерөнхий эрт цаг үе байна уу?

Орныг судлахдаа:

- Зохиолд үзүүлсэн орон бодит тодорхой газар орон байна уу? Эсвэл ерөнхий нэг орон байна уу?
- Ямар түлхүүр үгс болон ямар дүрслэлийг ашигласан байна вэ?



Уран зохиолын сурах бичгийн 55 дугаар талд буй Д.Давааням “Зүрх цагаан” өгүүллэгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1

Зохиолын орныг тодорхойлъя.

Алхам I. Зохиолоос орны утгатай үгсийг түүж бичээрэй.

1.	
2.	
3.	
4.	
5.	

Алхам II. Зохиолын орчны дүрслэлийг тайлбарлан, хүснэгтийг нөхөж бичээрэй.



Зүрх цагаан



Халтар нохой

Дүр	Хаанаас ирсэн бэ?	Хаашаа явсан бэ?	Яс хаяж өгөхөд ямар үйлдэл гаргасан бэ?	Дүрийн үйлдлийг дүрслэхдээ ямар ур маягийг ашигласан байна вэ?
Халтар нохой				
Зүрх цагаан				

Дасгал 2


Зохиолын цагийг тодорхойлъя.

Алхам I. Зохиолын үйл явдал хэзээ өрнөж байна вэ?

.....

.....

.....



Алхам II. “..... шөнө дөлөөр нэгэн хот айлын хажуугаар өнгөрч байв.” гэсэн өгүүлбэрт цэгийн оронд дүрслэл нэмж дэлгэрүүлж бичээрэй. Жишээлбэл:
“Саран нуугдсан шөнө дөлөөр нэгэн хот айлын хажуугаар өнгөрч байв.”




Дасгал 3




Орчин нь зохиолын гол санаанд хэрхэн нөлөөлж байна вэ?
Алхам I. Зохиолын гол санааг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрийг олоорой.

- А. Удам чинь улам олшрог.
- Б. Олз олонгуутаа аваад таг чиг болчихдог өчүүхэн амьтан
- В. Зүрх цагаан бүр гаарч, уул толгодыг доргитол боргоож амар заяа үзүүлэхгүй байв.

Алхам II. “Шөнө дөл, зүүн жалганы наанаас, уул нуруу, хөндий талыг доргитол боргоож...” гэсэн орчны дүрслэл гол санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэн бичээрэй.



Өөрийн үнэлгээ: Хүүхдүүд ээ, дараах хүснэгтэд ажилласан дасгалын дугаарыг бичээд, багшаасаа асуух, тодруулах, тухайн даалгаврын хүрээнд онцлон тэмдэглэх зүйлээ бичээрэй.

Маш сайн ойлгож хийсэн дасгал	Эргэлзэж хийсэн дасгал	Тусламж хэрэгтэй дасгал
		

3

Сурагчийн овог нэр:

Эхэлсэнонсар
.....өдөрцаг

Бүлэг сэдэв: Монголын уран зохиол өгүүллэг, тууж

Хичээлийн сэдэв: Уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүй үйл явдлыг товчилж бичих



Бид энэ хичээлээр юу мэддэг, чаддаг болох вэ?

Зохиолын орон ба цагийн дүрслэлийг ялган, хэрхэн дүрсэлснийг тайлбарлаж сурна.



Агуулгын товч тайлбар:

Сэдэв: Зохиолдоо бичихээр олж авсан зохиогчийн санаа бодлыг хэлнэ. Ихэвчлэн сэдэв гарчиг 2 тохирч байдаг. Зохиолд хэний тухай /юуны тухай/ гарч байна вэ?

Гол санаа /гол утга/: Зохиолчийн зүгээс уншигчдад хандаж хэлье гэж онцлон өгүүлсэн санаа. Энэ зохиолоос юуг ойлгов? гэдгээр илэрнэ. Сэдэв нь гол утга санааны хураангуй, гол утга санаа нь сэдвийн дэлгэрэнгүй дүрслэл гэж ойлгож болно.

Товчилж бичих: Зохиолын гол утга санааг алдагдуулахгүй гол үйл явдлыг хурааж бичих арга.



Уран зохиолын сурах бичгийн 72 дугаар талд буй Л.Түдэв “Хорвоотой танилцсан түүх” туужийг анхааралтай уншаарай.

Дасгал 1

Зохиолыг товчилж бичихдээ бэлтгэе.

Алхам I. Цэгийн оронд “Зурагтай танилцсан минь” зохиолын гол санааг гүйцээж бичээрэй.

.....
хүсэл мөрөөдөлдөө хүрч болдог.

Алхам II. Зохиолын эхлэл, гол, төгсгөл хэсгээс би баатарт тохиолдсон гол гол үйл явдлыг ялган бичээрэй.

Эхлэл

Бух зурчихлаа.

Lined writing area for notes.

Гол хэсэг

Амьтны дурс зурна.

Төгсгөл

Миний сонирхол оволзлоо.

Дасгал 2

Зохиолыг товчилж найруулан бичье.

Алхам 1. Зохиолын үйл явдлын дэс дарааг алдагдуулалгүй, өөрт таалагдсан үг хэллэг, дүрслэлийг ашиглан товчилж бичээрэй.

Тусламж

Товчилж бичихдээ: Дүрүүдэд ямар ямар үйл явдал тохиолдсон бэ?

Түүнээс хамгийн гол нь юу байв?


Голыг нь ялгахын тулд зохиолчийн санааг эргэцүүлээрэй.

Алхам II. Зохиолын үйл явдлын дэс дарааг алдагдуулалгүй, өөрт таалагдсан үг хэллэг, дүрслэлийг ашиглан товчилж бичсэнээ сайжруулж дахин сийрүүлээрэй.





Дууссанонсар
.....өдөрцаг

Өөрийн үнэлгээ: Хүүхдүүд ээ, дараах хүснэгтэд ажилласан дасгалын дугаарыг бичээд, багшаасаа асуух, тодруулах, тухайн даалгаврын хүрээнд онцлон тэмдэглэх зүйлээ бичээрэй.





Маш сайн ойлгож хийсэн дасгал






Эргэлзэж хийсэн дасгал





Тусламж хэрэгтэй дасгал



Бүлэг сэдэв: Дэлхийн уран зохиол үлгэр, өгүүллэг

Хичээлийн сэдэв: Зохиолын өгүүлэгдэхүүнийг үйл явдлын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллаар ялган таних



Бид энэ хичээлээр юу мэддэг, чаддаг болох вэ?

Зохиолын үйл явдлын бүтэц дарааллыг ялган таньж сурна.



Агуулгын товч тайлбар: Зохиолын үйл явдлын бүтэц дарааллыг зохиолын өгүүлэгдэхүүн гэнэ.

7. Зохиолын өгүүлэгдэхүүний зөрчил үүсэх суурь дэвсгэр бүхий үйл явдлыг **эхлэл** гэнэ.
8. Зохиолын үйл явдал үргэлжлэх зөрчил мөргөлдөөн үүсэх шалтгааныг зохиолын **зангилаа** гэнэ.
9. Зохиолын зангилаанаас учир шалтгааныг олохын тулд цааш үргэлжилж байгаа хэсгийг **өрнөл** гэнэ.
10. Зохиолын үйл явдал, зөрчил тэмцэл хурцдаж туйлдаа хүрсэн хэсгийг зохиолын **туйл** гэнэ.
11. Зохиолын зөрчил тэмцэл туйлдаа хүрч улмаар яаж шийдэгдэж байгааг **тайлал** гэнэ.
12. Зохиолын төгсгөлд баатруудын хувь заяа ямар болсон, зохиолч өөрөө хэрхэн үзсэн зэргээ илэрхийлснийг **төгсгөл** гэнэ



Уран зохиолын сурах бичгийн 85 дүгээр талд буй “Л.Н.Толстой “Шударга шүүгч” өгүүллэгийг анхааралтай уншаарай.

Дасгал 1

Зохиолын өгүүлэгдэхүүнийг ялган танья.

Алхам I. Зохиолын үйл явдлыг эхлэл, гол, төгсгөлөөр нь ялгасныг зөв харгалзуулаарай.

1. Эхлээд юу болсон бэ?

А. Баукас өөрийгөө хаан гэдгээ хэлж, шударга шүүгчид шагнал өгье гэсэн боловч татгалзжээ.

2. Дараа нь яав?

Б. Худалдаачны дүрд хувирсан Баукас хаан шударга шүүгч рүү очих замдаа доголлон эртэй таарч морио булаацалдав.

3. Эцэст нь юу болж өнгөрөв?

В. Шударга шүүгчид очиж хэргээ үнэн зөв шийдүүлэв.

Алхам II. Зохиолын эхлэл хэсэгт юуны тухай гарсан бэ?

А. Алжирын хаан Баукас шударга шүүгчтэй уулзахаар болсон.

Б. Алжирын хаан Баукас шударга шүүгч рүү очих замдаа доголон эртэй таарсан тухай.

В. Алжирын хаан Баукас, доголон эр хоёрын уулзсан тухай.

Дасгал 2

Зохиолын гол хэсгийн үйл явдлыг ялгаарай.

Алхам I. Зохиолын гол үйл явдал өрнөх шалтгаан нь юу байсан бэ?



А. Баукас хаан доголон эрийн морийг булаасан.

Б. Доголон эр Баукас хааны морийг минийх гэж зүтгэсээр маргаан болсон.

В. Баукас хаан, доголон эр хоёр маргалдсан.

Г. Хүмүүс Баукас хаан, доголон эр хоёрыг шүүгчид оч хэмээсэн.

Алхам II. Зохиолын баатруудад цаашид юу юу тохиолдсон бэ? Гурваас доошгүй үйл явдлыг зохиолоос түүж бичээрэй.

1.

2.

3.

Алхам III. Үйл явдлын зөрчил туйлдаа хүрсэн хэсэг хаана байна вэ? Зөв хариултыг сонгоорой.

А. Шүүгч: -Морь чинийх, аваад яв гээд доголонг басхүү тавин удаа саваадах тушаал өгөв.

Б. Шүүхийн дараа шүүгч гэр лүүгээ явахад Баукаас түүний араас дагав.

В. Гагцхүү эхнэр эрдэмтнийх, мөнгө махны худалдагчийнх, морь минийх гэж та яаж мэдэв гэдгийг л мэдэх гэсэн юм.

Г. Би худалдаачин биш, хаан Бауакас.

Дасгал 3

Зохиолын төгсгөл хэсгийн үйл явдлыг ялгаарай.

Алхам 1. Үйл явдлын зөрчил яаж тайлагдав? Өөрийн үгээр хураан бичээрэй.

Эхнэрийн тухай бол, би түүнийг өглөө дуудаад: -Янтайд бэх хийгээдэх гэлээ. Эхнэр янтайг хурдан угааж цэвэрлээд их л дадамгайгаар бэх хийж сурсан нь нүдэнд илхэн байлаа. Хэрвээ хархүүгийн эхнэр байсан бол үүнийг хийж чадахгүй байсан юм. Ингэхлээр эрдэмтний үнэн ажээ.

Мөнгөний тухайд бол, мөнгийг би аягатай усанд хийгээд хонолоо л доо. Өглөө босоод усан дээр тос хөвж байна уу, үгүй юу гэдгийг харлаа. Мөнгө хэрвээ тосны худалдагчийнх байсан бол бөөн тостой байх ёстой сон. Усан дээр тос хөвж харагдсангүй. Ингэхлээр махны худалдагчийн үнэн ажээ. Морины талаар мэдэх нэлээд хэцүү байлаа. Доголон эр хорин морины дотроос чиний морийг яг л чам шиг шууд л олсон шүү дээ. Гэхдээ би зөвхөн та хоёрын морио таньж байна уу, үгүй юу гэдгийг мэдэх гэсэн юм биш, харин та хоёрын хэнийг чинь морь таньж байна гэдгийг харах гэсэн юм. Чамайг ойртоод очтол морь толгойгоо чам руу хандуулан, чиний зүг тэмүүлээд байсан. Доголон эрийг ойртоод очтол морь чиний хувийг харж тос хөвж байсан юм. Ингэхлээр чамайг хийхүснэ гэсэн нь мөн бодгийг

Жишээ нь: Шүүгч: Эхнэрийн янтайд их л дадамгайгаар бэх хийснийг хараад, мөнгийг аягатай усанд хийгээд хонуулахад тос хөвөөгүйг ажиглаад, Баукасыг ойртоод очтол морь толгойгоо хандуулан, тэмүүлэхийг үзээд эрдэмтэн, махны худалдагч, Баукасын үнэн болохыг мэдсэн юм.

.....

.....

.....

.....

.....


.....

.....

.....

.....

.....



Алхам II. Зохиолын төгсгөл хэсгийг уншаад, дүгнэлт бичээрэй.

-Би худалдаачин биш, хаан Баукаас. Чиний тухай яриа үнэн үү, худлаа юу гэдгийг нүдээр үзэхээр ирсэн юм. Ингээд чи үнэхээр мэргэн шүүгч юм гэдгийг харлаа. Юу хүсэж буйгаа хэл, би чамайг шагнаа гэхэд шүүгч:

“Надад ямар ч шагнал хэрэггүй” гэж харивлжээ.



-Баукаас хаан яагаад худалдаачны дүрээр шүүгчтэй уулзсан бэ?
-Шүүгч яагаад шагнал авахаас татгалзсан бэ?
-Шүүгчийн зан чанараас юуг ойлгосон бэ?
-Шүүгчийн оронд чи байсан бол яах байсан бэ?

Дасгал 4

Зохиолын өгүүлэгдэхүүнийг асуулттай нь зөв харгалзуулаарай.

1. Эхлэл

2. Зангилаа

3. Өрнөл

4. Туйл

5. Тайлал

6. Төгсгөл

А. Баатруудад юу юу тохиолдов?


Б. Зохиол яаж төгсөв?

В. Үйл явдлын зөрчил яаж тайлагдав?

Г. Зохиолд юуны тухай гарах бол?

Д. Үйл явдлын зөрчил туйлдаа хүрсэн хэсэг хаана байна вэ?

Е. Үйл явдал өрнөх шалтгаан нь юу вэ?



Дасгал 1


Зохиолын сэдэв, гол санаа, дүрээс төрсөн мэдрэмжээ илэрхийлье.
Алхам I. Зохиолд юуны тухай өгүүлсэн бэ?

.....
.....




Алхам II. Базсан цаасны хэлсэн үгийг уншаад чамд ямар мэдрэмж төрсөн бэ?

Зузаан нимгэн номын цаас
Зурагтай сонин сэтгүүлийн цаас
Гагцхүү эндээс гардаг цаас
Гараг дэлхийг бүрхдэг цаас...
Хаясан цаас голсон цаас
Халуун тогоо руу харайн орж
Эрэлхэг зоригт хуучин цаас
Энэ дэлхийд дахин төрнө...



.....
.....
.....
.....

Алхам III. Сакуны дүрээс төрсөн мэдрэмжээ илэрхийлэн бичээрэй.



Дасгал 2

Зохиолоос төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн бичье.
Алхам I. Зохиолоос чи юу, юу ойлгож авсан бэ?

- ✓
- ✓
- ✓

Алхам II. Зохиолын гол санаанаас төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлээрэй.



.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....




Дууссанонсар
.....өдөрцаг


Өөрийн үнэлгээ: Хүүхдүүд ээ, дараах хүснэгтэд ажилласан дасгалын дугаарыг бичээд, багшаасаа асуух, тодруулах, тухайн даалгаврын хүрээнд онцлон тэмдэглэх зүйлээ бичээрэй.



Маш сайн ойлгож хийсэн дасгал



Эргэлзэж хийсэн дасгал



Тусламж хэрэгтэй дасгал

